



ҮНДСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ДУНДГОВЬ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг  
Сайнцагаан сум, Нарлаг баг  
Утас 70-59-24-33 70-59-22-08, 70-59-32-08  
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.03.16. № 96.

ӨЛЗИЙТ СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
П.АЛТАНТУЯА ТАНАА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын үр дүнд нийцлийн аудит хийх явцад Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 13,700,000.00 төгрөгийн өртөгтэй “Сургуулийн дотуур байрны халаалт, ариун цэврийн өрөөний тохжилт”-ын ажлыг бүртгээгүй, санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д /Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ/. 14.4.2.-т /бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;/, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан “Орон нутгийн хуулийн этгээдийн олж авсан эд хөрөнгийг бүртгэх”-журмын 3 дугаар зүйлийн 3.2-т /Улсын хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн барилга байгууламж, их засварын ажил, худалдан авсан тоног төхөөрөмж, бусад үндэсн хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан Улсын комисс /Ажлын хэсэг/-ын акт, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн зохих баримт материалыг үндэслэн тухайн төсөл хэрэгжсэн байгууллага нь тайлан балансдаа шууд бүртгэн авна/, гэсэн заалтыг тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн A/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.7-д /Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1701500712

1. 2017 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайланд “Сургуулийн дотуур байрны халаалт, ариун цэврийн өрөөний тохжилт”-ын ажлыг бүртгэж, санхүүгийн тайланд тусгах,
2. Албан шаардлагын биелэлтийг 2017 оны 04 дугаар сарын 25-ны дотор аймгийн Аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Өлзийт сумын Засаг дарга П.Алтантуяа, няглан бодогч Г.Мөнхбаясгалан нарт хариуцуулав.

### АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН<sup>2</sup>:

АХЛАХ ШИНЖЭЭЧ

Д.ИХБАЯР

ЗАХИРАЛ

ЗӨВШӨӨРСӨН:

П.АЛТАНТУЯА

НЯГТЛАН БОДОГЧ Г.МӨНХБАЯСГАЛАН

<sup>2</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.